

**УЛААНБААТАР ХОТЫН ДЭРГЭДЭХ БОГДХАН УУЛЫГ САХИН ХАМГААЛАХ ДҮРЭМ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДЭРГЭДЭХ  
БОГДХАН УУЛЫН САХИН ХАМГААЛАХ ДҮРЭМ**

**БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ДЭРГЭДЭХ  
БОГДХАН УУЛЫН САХИН ХАМГААЛАХ ДҮРЭМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**

**ЕРӨНХИЙ ХАМГААЛАХ БОДЛОГО ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Үндсэн хуулийн ёсоор харьяат нутгийг баялгийг хувийн өмч болгохгүй ард нийгмийн хөрөнгө болгож улсын эдийн засгийг хөгжүүлэхийн учраа аж ахуйн яамнаас эрхлэн улсын ард олны нутгийн төв дэх үзэсгэлэн ба ой ан бүхий Богдхан уулын тусгайлан цаазалж аливаа бодис зүйлийг туйлын нарийн чангаар сахин хамгаалуулбаас зохимуй.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Тус уулыг эрхэм байдал баялаг бүхий талаар сахин хамгаалахын учир аливаа бодит үзэх олон зүйлийн ургамал бодис ба төрмөлийн аймаг элдэв зэрлэг амьтдыг ашиглан алах угталгуулахыг /гаргацгүй/ бүрнээ цаазалж эдгээрийн оршсон байдлаар эргэн тойронд уул газрын хамгаалагдах хил тохируулан тогтоож хооронд тус тус арван модон бээр хэмжээ болгон овоо тэмдгийг байгуулбаас зохимуй.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Сахин хамгаалах хэргийг ёсчлон гүйцэтгүүлэхийн тул зохих тооны дарга ба цагдаа нарыг албаны үнэмлэх зохих тэмдэг хэрэгсүүлэн олгож мөнхүү уулыг тойрсон нэр агч ихээхэн хорин нэгэн ам газрын их багын байдал хэмжээнд тэгшитгэн хувиар барьцааг тохируулан ноогдуулж бүхийлэн хамгаалах үүргийг чанга чанартай цагдуулбаас зохимуй.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Харьяат дарга нар цагдаа нар ноогдсон газруудын аливаа сахин хамгаалах хэргийг зориуд хайхрамжгүй зэргээс цалгардуулан хорлол харшлал болгох зэрэгт хүргүүлж хэрхэвч үл болмуй.

Нэмэн тэмдэглэх нь: Харьяат дарга цагдаа нар албаны зохих зэвсгийг хэрэглэн зөвхөн хувийн гэр бүл малын хамтад сууж хуурай унамал хожуул мод бэлчээрийг маш гамтайгаар хэрэгсэх хэрэгсэх ба хэрвээ хэр хэмжээнээс хэтрэх буюу хувийн ашгийг эрмэлзэн хуйвалдах мэтийн үл зохилдох гэмт явдал үйлдвээс зохих газар шилжүүлэн хууль ёсоор цээрлүүлэн шийтгүүлмүй.

**ТАВДУГААР ЗҮЙЛ.** Улсын эрхлэн цаазалсан энэхүү хэмжээт газрын дотоод жинхэнэ цагдаа цэргээс бусад аливаа хүмүүс дураар эзэрхэн орж, буудаллах хийгээд мал бэлчээрлэж хэрхэвч үл болмуй. Хэрвээ албан буюу хувийн онц зориуд хэрэг холбогдвоос тухай бүр аж ахуй яамнаа мэдүүлэн зохих татвар зөвшөөрөл үнэмлэхийг авч зааж тогтоосноор дагаж явахаас гадна энгийн цааш нааш замнан явагчид түр зугаацагчид зориуд хэрэг зэргээр явагчид цөм энэхүү дүрмийн долоодугаарт заасныг баримталбаас зохимуй.

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Жинхэнэ хамгаалсан бодит зүйлийн бус гаднах үхэж хатсан мод хожуул адаг бэлийн сул сийрэг бэлчээр буудлыг тусгайлан түр зохихыг үзэж тохируулан

заавар зөвшөөрлөөр хэрэглүүлж болох учир харгалзах одох цагдаа цэрэг ба аливаа нэгэн зөвшөөрөл бүхий зэрэг гарз тохиолдогчид хэн хүмүүс таширмаглан далимдуулж цааш үйсэн баялагт хор хөнөөл өдүүлэхгүй агуулсан хэвээр байлгахыг хууль зүйн дотор шууд өөрсөд ба сахин хүлээж хувийн галт буюу ирт буу зэвсэг багаж нохой зүйлийг хайхрамжгүйгээр хандуулан зориулж осол сул хаях агуулах зэргийн ямар нэгэн сүйтгэлд хүргүүлэхгүйг туйлын хичээх үүрэг болговоос зохимуй.

Нэмэн тэмдэглэх нь: Ялангуяа галлахад аваас ургамалгүй нүцгэн чөлөөтэй элс шавар дээр хэрэгсэн орхих бүрт унтрааваас зохимуй. Хэрвээ үл хайхран осолдон дэгдүүлэх буюу хөрс шороог журмаар ухаж малтваас намын дүрмийн тавдугаар бүлгийн ёсоор явуулж тогтоосныг зөрчсөнийг ял сүйтгэлийг үүсгэгчдэд тулган шийтгүүлмү.

**ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Цаазлагдсан газрын хэн хүн зөвшөөрөл үнэмлэхгүйгээр аль ч цагт ... зэрлэг амьтан моджилт зэрэг аливаа төрмөл ургамлын зүйлийг алах эвдэх зэргээр ашиглах сүйтгэл бусниулах зэргийн этгээд гарах ахул түүнийг багаж хэрэгсэл ашигласан зүйлүүдийг бүрэн албанд хурааж зөрчсөн хууль ёсоор сүйтгүүлбээс зохимуй.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### ТУСГАЙ ХАМГААЛАХ ХЭМЖЭЭ ЯЛГАВАР

**НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Цаазлагдсан газрын зах сав буюу ургамлын зүйл үлэмжхэн зууралдаагүй ба тогтууртай ангийн амьтдад харшлахгүй зэрэг зохих газарт нутаглахыг хүсэгчид тухай бүх хянан зөвшөөрлийг олгоход мөн уулын эргэн тойрон дахь хорин нэгэн ам газар адаг бэл тутамд нэг бүр нэгэн удаа (1)-ээс нэг зуун хорь хүртэл (2) хоёр хувийн өрх арван таван (3) нас гүйцсэн ам жар (7) өмчийн бод мал бүгд нийлж туйлын гадна өрх бүр арван тав (5) хонь ямаа нийлж хориос дээшгүй аваас болмуй.

(2) жич (9) Бие зугаацахаар зэрэг уулын жинхэнэ ой модонд явагчид (2) зохих албан хэргээр явах баримттай этгээдэд нэгэн өдрөөс хэтрүүлэхгүй хэмжээ болгох эрх олговоос зохимуй.

Нэмэн тэмдэглэх нь: Зугаацахаар явахаас бус зориуд буюу жинхэнэ албаны хэрэг учрыг тухайн цагдаад мэдэгдвээс зохимуй.

**ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Үнэхээр үхэж хатсан хуурай ногоо буюу унамал хамгаалагдсан зүйлд үл харшлагад аваас дэвсгэрийг ангилан тэмдэг тавьж эцсийн бодлогод нийлүүлэн зохих хэмжээ хугацаагаар ашиглуулах ба цэвэрлүүлэхдээ гагцхүү улаан цэрэг ба зохих сургууль жич өлсгөлөн ядуусыг тэтгэх түлшинд зохихыг үзэж боловсон аргаар харшгүй ажиллуулан хэрэгсүүлж болохоос гадна мөн туйлын гар хоосон ядуу бүхий бөгөөд явган биеэр унасан мөчир хожуул өгөрхийлөн түүхий хүсэгчдэд хэрэглүүлмүй. Бусад аливаа олон нийтийн газрууд буюу хувийн хөрөнгө амьдралд хэрэглүүлэхийг хязгаарлаваас зохимуй.

Нэмэн тэмдэглэх нь: зохих мод мөчрийг авахыг дашрамдуулан сүйтгэх хэмжээ илүүдүүлэн үйлдэх ашиглах хугацаа өнгөрүүлэх зэргийн харштай явдал өдүүлбээс уг зүйлийг хурааж зөрчсөний хуулийн ёсоор шийтгүүлэхээс гадна улаан цэргийн хот лагерийн бэлтгэл агт ба аливаа яам олон нийтээр . . . газруудын албан хэрэглэл буюу бусад хүмүүсийн уналгын морь мал идэшлүүлэхийг хүсэх аваас тухай бүр зохих газар ба хүмүүсээс тоо зэргийг учрыг тодорхойлон аж ахуйн яамнаа мэдүүлэн зөвшөөрлийг авч гүйцэтгэвээс зохимуй.

**АРАВДУГААР ЗҮЙЛ.** Эл ашиглуулахыг туйлын нарийвчилбаас зохих үүнд нэг, хэчнээн хэмжээ хэмжээнд ямар янзын модыг хэдий хугацаагаар аль нутагт захиран ямар хөрөнгө, хэн хэдэн хүнийг хэчнээн хөсөг хэрэглүүлэлтэй хэрхэн үзэж үйлтгүүлэх гэрээ хэлэлцээ, мөн нутаг захиргаа хаана суух, хэн хэн хэрхэн ядмагаас юмыг үүрлэн (3) эдгээрийн жинхэнэ буюу түр захиргаанаас үнэн ташааг илрүүлсэн хуудасны зэрэг бат баримт (4) нутаглах бэлчээрлэхийг хаан хүсэх, хувийн өрх, ам мал адгуус зэвсэг хэрэгслийн үнэн нэр тоо зэргийг урьдаар тодорхойлуулан хянаж тогтоовоос зохимуй.

**АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Дээрх зүйл ангид дурьдсан аливаа албан амины өрх биеэр тусгайлан батлуулагчид ба мал бэлчээрлүүлэн идээшлүүлэгчид элдэв түлшийг мод авагчид тутам тусгай үнэмлэх хуудас тэмдэгтийг учир тодорхой бичиж хүн бүр буюу өрх хэсгийн тэргүүлэгчдэд хамтатган олгуулж тутамд нэг төгрөг хураамуй.

Нэмэн тэмдэглэх нь: үүнд тусгай суугаа элчин төлөөлөгч үл орлохоос гадна хугацаа гүйцэхийн өмнө өвсөө сэм нэмэгдүүлбээс шууд зайлуулах буюу зөрчсөн ёсоор шийтгүүлмүй.

**АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хамгаалсан уул усны аливаа хүнээс жинхэнэ сонирхон үзэх зугаацах зэргээр явахыг хүсэгчинд үнэмлэхийг олгох явдалгүй гагцхүү орох гарахад цагдаадуудад учрыг мэдүүлбээс зохимуй. Жич жинхэнэ сургуулийн сурагчдад тусгай тушаалтай зориуд бүлгээр түр суух явах аваас уг хүн тоо хугацааг тодорхойлсон үнэгүй үнэмлэх бичиг олгомуй.

**АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Тус ууланд дулааны улирлаар ургах цэцэг эмийн зүйл ба үзэсгэлэн мүжтд хэрэглэх зүйлийг үл авах нь болбоос эрхлэх газруудаас тухай бүр одох хоногийн тоо ихийг урьдаар тодорхойлон аж ахуй яамнаа мэдүүлэн гүйцэтгүүлэхээс гадна сул хэвтэх ясан эвэр ба үхсэн араатан гөрөөс зүйл ямар ч хүн олох аваас зохих газар хэвээр хүргэн ирж хураалгаваас зохимуй.

**АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Энэхүү дүрмийг тогтоон зарласан өдрөөс эхлэн дагаж шийтгүүлэн урьд энэ тухайн тогтоосон тогтоолыг дүрэм хүчингүй болмуй:

Монгол улсын арван есдүгээр он арван сарын таван.